



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2015 оны 12 сарын 24 өдөр

Дугаар

0/540


Арвайхээр

Хөтөлбөр батлах тухай

Өвөрхангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.4.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Залуу малчдыг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлж, хяналт тавьж, тайлагнан ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /С. Цэдэнбалжир/, Хөдөлмөрийн хэлтэс /П.Пунсалмаа/ болон сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д. ТОГТОХСҮРЭН

02 1232

Аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 95 дугаар захирамжийн хавсралт

“ЗАЛУУ МАЛЧДЫГ ДЭМЖИХ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал

Аймгийн мал сүргийн тоо 2015 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 4,5 сая толгойд хүрч бүх мал сүргийн 0,4 хувийг тэмээ, 5,0 хувийг адуу, 3,9 хувийг үхэр, 46,7 хувийг хонь, 44,0 хувийг ямаа эзлэх болж энэ салбараас жилд дунджаар 2300,0 орчим мянган тн ноос, 550,0 орчим тн ноолуур, 1546,0 орчим мянган тн мах, 2978,0 мянга орчим литр сүү, 700,0 орчим мянган ширхэг арьс, шир бэлтгэн дотоод гадаадын эах зээлд нийлүүлж байгаа нь аймгийн ДНБ-ий 64,0 орчим хувийг эзэлж байна. Аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд мал аж ахуйн салбар нь голлох үүргийг гүйцэтгэж байна. Сүүлийн жилүүдэд мал сүргийн тоо тогтвортой өсч байгаа боловч мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа малчдын тоо жилээс жилд буурч, нэгж малчинд ногдох малын ачаалал нэмэгдэж байгаагаас мал аж ахуйн салбараас үйлдвэрлэх бүтээгдэхүүний нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүйд хүрч, эдийн засгийн үр ашиг буурах хандлага ажиглагдах боллоо. Аймгийн хэмжээгээр 2009 онд мал аж ахуйн салбарт 32,8 мянган малчин ажиллаж, нэг малчинд 91 толгой мал ногдож байсан бол 2014 онд 27,7 мянган малчин ажиллаж нэг малчинд 148 тоглой мал ногдож байна. Сүүлийн 6 жилд мал аж ахуйн салбарт ажиллагсдын тоо 15,6 хувиар буурч, нэгж малчинд ногдох малын тоо 60,0 орчим хувиар нэмэгдсэн байна. Ялангуяа малчдын залгамж халаа болсон залуучууд энэ салбарт ажиллаж, амьдрах сонирхол бага болж, төв суурин газрын амьдралд илүү тэмүүлэх болсон нь мал аж ахуйн салбарт ажиллах хүчин дутагдах, нүүдэлчдийн зан заншил, өв соёл, өвөг дээдсээс уламжлагдаж ирсэн нутаг ус эзэнгүйрэх, төвлөрөл дагасан ажилгүйдэл нэмэгдэх зэрэг сөрөг үр дагаваруудыг бий болгоод байна. 2009 онд мал аж ахуйн салбарт 16-35 насны 15,3 мянган залуучууд ажиллаж бүх малчдын 46,6 хувийг эзэлж байсан бол 2014 онд 10,7 мянга болж нийт малчдын 38,6 хувийг эзэлж байна.

ХОЁР: ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Аймгийн эдийн засгийн голлох салбар болсон мал аж ахуйд сүүлийн жилүүдэд мал сүргийн тоо толгой тогтвортой өсч, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж байгаа боловч энэ салбарт ажиллах залуу малчдын тоо жилээс жилд цөөрч байгаа нь эцэг өвгөдөөс уламжлагдаж ирсэн нутаг ус эзэнгүйрэх, нүүдэлчин удмын ёс, зан заншил алдагдах, нэгж малчинд ногдох малын ачаалал нэмэгдэх, эдийн засгийн үр ашиг буурах хандлага ажиглагдах болсон зэрэг нь энэ хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болсон бөгөөд энэхүү хөтөлбөр нь улс, аймгаас гаргасан дараах баримт бичгүүдийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл нь болох юм. Үүнд:

2.1. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөр,

2.2. Засгийн газрын 2003 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" хөтөлбөр,

2.3. "Мал аж ахуйн талаар баримтлах аймгийн бодлого" болон бусад холбогдох бодлогын баримт-бичгүүдийг хэрэгжүүлэх

2.4. Монгол Улсын Засгийн газраас малчдын залгамж халаа болсон шинэ залуу малчдыг бэлтгэх, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тавьсан бодлого чиглэлийг хэрэгжүүлэх

2.5. Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: Бэлчээрийн мал аж ахуйг зах зээлийн эрэлт хэрэгцээ, бүс нутгийн онцлог, бэлчээрийн даацад тохируулан үр ашигтай эрхлэн хөтлөх, малчин өрхийг үйлдвэрлэгч болгох, сайн малчдын тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлж, тэдний залуу халааг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд залуу малчдыг дэмжих аймгийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

ГУРАВ: ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа залуучуудад эдийн засаг, нийгмийн дэмжлэг үзүүлэх, мал маллагааны уламжлалт арга туршлагыг өвлүүлэх, мал аж ахуйгаа эрхлэн хөтлөх менежментийн боловсрол эзэмшүүлэх замаар мал аж ахуйн салбарт ажиллах залуу малчдын тоог нэмэгдүүлэхэд оршино.

ДӨРӨВ: ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

4.1 **Нэгдүгээр тэргүүлэх чиглэл:** Залуу малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлж, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах.

4.2 **Хоёрдугаар тэргүүлэх чиглэл:** Залуу малчдын амьдралын дадал, заншилд тулгуурлан боловсрол, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх.

4.3 **Гуравдугаар тэргүүлэх чиглэл:** Залуу малчдын хөдөлмөрийг үнэлэх, алдаршуулах, урамшуулах.

ТАВ: ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Нэгдүгээр тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1 Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр тогтвор суурьшилтай ажиллаж байгаа боловч амьжиргааны түвшингээс доогуур орлоготой цөөн малтай залуучуудыг эхний ээлжинд малжуулах төсөлд үе шаттай хамруулах замаар өрхийн хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц тооны малтай болгох.

5.2 Шинээр мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа залуучуудад гэр орон, малынхаа хашаа байр барих, худаг уст цэг гаргах, хадлан тэжээл бэлтгэх зэрэг мал

аж ахуйн материаллаг баазаа бэхжүүлэхэд нь орон нутгаас хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх.

- 5.2.1 Ерөнхий боловсролын сургуулиа төгсөөд малчин болж мал аж ахуйн үйлдвэрлэл дээр тогтвор суурьшилтай ажиллаж байгаа залуу малчдыг цэргийн албыг дүйцүүлэн хаах боломжийг бүрдүүлэх.
- 5.2.2 Малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах оновчтой арга механизмыг бий болгох, гэр цэцэрлэг, зуны цэцэрлэг ажиллуулах
- 5.2.3 Ерөнхий боловсрол эзэмших болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцахад нь дотуур байраар хангахад дэмжлэг үзүүлэх.
- 5.2.4 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх залуу малчин өрхөд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд газрыг эзэмшүүлэх.
- 5.2.5 Залуу малчдыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах.
- 5.2.6 Малчдын амьдрал, ашиг орлогыг сайжруулахад чиглэгдсэн гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт залуу малчдыг хамруулах.
- 5.2.7 Малчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, сум, багийн эмнэлгийг боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах.
- 5.2.8 Мал аж ахуйн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг судалж, мал, амьтнаас хүнд дамжин халдварлах өвчнөөс малчид, хүн амыг хамгаалах болон осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, ахуйн болон ундны цэвэр усаар хангах.
- 5.2.9 Малын хашаа, дулаан байрны зураг төсөл гаргаж материалын нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх.
- 5.2.10 Малчдыг байгалийн гамшгийн үед өмсөхөд зориулсан дулаан, тохиромжтой хувцасаар хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААНэгжүүдийг дэмжих.

Хоёрдугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 5.2.1 Залуу малчдад тэдний эдийн засаг, бизнес, ур чадварын түвшинд нийцсэн сургалтын ялгавартай хөтөлбөр бий болгож хөгжүүлэх, мэргэшсэн сургагч баг нарыг бэлтгэн сум бүрт бий болгож, залуу малчдын дунд байнгын сургалт зохион байгуулах.
- 5.2.2 Аймгийн МСҮТөвийг түшиглэн дадлагын байр бий болгон сургалтын баазыг бэхжүүлж, залуу малчдыг сургаж мэргэшүүлэх, мэргэжилтэй малчин бэлтгэх
- 5.2.3 Интернет, цахим техник, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан залуу малчдын дунд зайны сургалтын системийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах.
- 5.2.4 Залуу малчдад улс, аймгийн тэргүүний малчдын туршлагыг газар дээр нь явж судлуулах ажлыг жил бүр зохион байгуулах.
- 5.2.5 Гадаад, дотоодын эрчимжсэн мал, аж ахуйн туршлагыг залуу малчдад түгээн дэлгэрүүлэх, туршлага судлах ажлыг зохион байгуулах.

- 5.2.6 Залуу малчдад бизнес, санхүү, зээл, хууль зүйн туслалцаа үзүүлэх, мал эмнэлэг, үржлийн болон хөдөө аж ахуйн шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх үйлчилгээг орон нутагт хөгжүүлэх.
- 5.2.7 Залуу малчдыг дүйцсэн сургалтын хөтөлбөрт хамруулан зохих журмын дагуу бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх.
- 5.2.8 Залуу малчныг малчдын бүлэг, хоршоонд хамруулж тэдний хөдөлмөрийг хорших хамтын хөдөлмөрийн давуу талыг ойлгуулах.

Гуравдугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 5.3.1 Аймаг, сумаас мал сүргээ тогтвортой өсгөж, амжилт гаргаж байгаа залуу малчдыг дэмжиж, жил бүр аймаг-8-с доошгүй, сум 2-с доошгүй залуу малчдыг шалгаруулан шагнах.
- 5.3.2 Мал аж ахуйн үйлдвэрлэл, технологийн чиглэлээр ажил мэргэжлийн уралдааныг жил бүр зохион байгуулж, дүгнэх.
- 5.3.3 Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр тогтвортой амжилт гаргаж байгаа залуучуудыг дэмжиж төрийн захиргааны байгууллагын шагнал, төрийн одон медальд тодорхойлн шийдвэрлүүлэх.
- 5.3.4 Малчин залуучуудын чуулга уулзалтыг суманд 2 жилд, аймагт 4 жилд нэг удаа зохион байгуулж, тэргүүний малчин залуучуудыг шалгаруулан урамшуулах, тэдний арга туршлагыг сурталчилж нийтийн хүртээл болгох.
- 5.3.5 Төвийн болон орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдээр мал аж ахуйн үйлдвэрлэл дээр бусдыгаа үлгэрлэн ажиллаж байгаа залуучуудынхаа амжилт ололтыг сум орон нутаг, орон даяар сурталчлах, алдаршуулах.

ЗУРГАА: ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

6.1. Энэхүү бодлогын баримт бичиг нь аймгийн мал ахуйн салбарт ажиллаж байгаа малчдын залуу халааг дэмжих 2016-2020 оны зорилтуудыг тодорхойлно.

ДОЛОО: ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 7.1. Хөтөлбөрийг аймгийн түвшинд зохион байгуулж хэрэгжүүлэх үүргийг аймгийн ЗДТГ, аймгийн Засаг даргын дэргэдэх ХХААГазар хариуцна.
- 7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүргийг Хөдөлмөрийн хэлтэс хариуцна.
- 7.3 Сум орон нутгийн түвшинд зохион байгуулах үүргийг тухайн шатны Засаг дарга, МЭҮТасгийн болон хөдөлмөр хариуцсан мэргэжилтнүүд тус тус зохион байгуулна.
- 7.3. Хэрэгжилтийг ХХААГазраас жил бүр гаргаж дүнг дараа оны 1-р улиралд аймгийн Засаг даргын зөвлөлд тайлагнана.

НАЙМ: ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

8.1. Мал аж ахуйн салбарт ажиллах хүчний хангамж сайжирч, нийт малчдад эзлэх залуу малчдын хувийн жин нэмэгдснээр эрсдэл даах чадавхитай мал аж ахуй бий болж малчдын ашиг орлого тогтвортой нэмэгдэх боломж бүрдэнэ.

8.2. Нутаг ус, бэлчээр эзэмшилтэй болж, бэлчээр ашиглалтад ахиц дэвшил гарна.

8.3. Нүүдэлчдийн өв соёл, ёс заншил мартагдах байдал багасч, мал маллагааны уламжлалт арга туршлагыг залуу халаа малчдад өвлүүлэх боломж бүрдэж эхэлнэ.

ЕС: ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

9.1. Мал ахуй дээр шинээр гарч ажилласан залуу малчдын тооны өсөлтөөр

9.2. Мал аж ахуйн үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа малчдад 16-40 хүртэлх насны залуучуудын хувийн жингийн өсөлтөөр

9.3. Залуу малчдад оруулсан хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлийн хэмжээгээр

АРАВ: ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ ШИНЖИЛГЭЭ

10.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт, шинжилгээ-үнэлгээг аймгийн ЗДТГ-ын хяналт, үнэлгээ-шинжилгээний баг болон аймгийн Засаг даргын дэргэдэх ХХААГазрын дотоод хяналтын нэгж хийж, арга зүйгээр хангана.

АРАВАН НЭГ: ХӨРӨНГӨ САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүү нь дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ. Үүнд:

11.1. Улс, орон нутгийн төсөв,

11.2. ОНХСан

11.3. Малжуулахад зориулсан хөрөнгө

11.4. Төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт

11.5. Мал аж ахуйн татвараас бүрдсэн хөрөнгө оруулалт

11.6. Малчдын хувийн хөрөнгө оруулалт

11.7. Бусад эх үүсвэр